



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 4/305

Улаанбаатар хот

Монгол улсын их сургуулийн судалгааны
хүрээлэн, төвийн үйл ажиллагааны
журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монгол Улсын Их сургуулийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталж, 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Захирлын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалаар батлагдсан “Монгол улсын их сургуулийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. “Монгол Улсын Их сургуулийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам”-ыг МУИС-ийн цахим хуудсанд байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Судалгаа хөгжүүлэлтийн газрын дарга (Н.Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (Ц.Баатарчулуун), Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б.Даваасүрэн) нарт тус тус даалгасугай.

РЕКТОР




Б.ОЧИРХУЯГ

1426132318

Монгол Улсын Их Сургуулийн ректорын
2026 оны 06 дугаар сарын 19 ны/ний өдрийн
дугаар/дүгээр тушаалын хавсралт

A/305



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. Журмын зорилго


1.1 Хүрээлэн, төвийн үйл ажиллагаа нь Монгол улсын Боловсролын Ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, “МУИС-ийн Стратеги Төлөвлөгөө 2025-2030” болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийг баримтлан Монгол Улсын Их Сургуульд судалгааны хүрээлэн, төв (цаашид “хүрээлэн, төв” гэх) байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааг үнэлэх, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Журмын нэр томъёоны тодорхойлолт

- 1.2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
- 1.2.2 “Хүрээлэн” гэж салбар дундын цогц асуудал шийдвэрлэх зорилгоор судалгааны үйл ажиллагаа явуулдаг, хоёр ба түүнээс дээш бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш, судлаач болон гаднын байгууллагын судлаачдаас бүрдсэн бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга нь наймаас доошгүй, үүсгэн байгуулах саналыг холбогдох бүрэлдэхүүн сургуулиас дэвшүүлдэг МУИС-ийн нэгжийг;
- 1.2.3 “Төв” гэж тодорхой салбарын судалгаа болон үйлчилгээ эрхлэн явуулах зорилго бүхий нэг эсхүл хэд хэдэн тэнхим болон бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш, судлаачдын бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга гурваас доошгүй, үүсгэн байгуулах саналыг тэнхимээс дэвшүүлдэг бүрэлдэхүүн сургуулийн нэгжийг;
- 1.2.4 “Үүсгэн байгуулагч” гэж Монгол Улсын Засгийн газар, төрийн болон хувийн хэвшил, олон улсын байгууллага, гадаадын их дээд сургууль, МУИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, тэнхим;
- 1.2.5 “Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төв” гэж Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулагдан шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл, цөм технологийн чиглэлээр судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн, төвийг;
- 1.2.6 “МУИС-ийн хүрээлэн, төв” гэж МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдан судалгааны тэргүүлэх чиглэл, цөм технологийн судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн, төвийг.

1.3 Нийтлэг зарчим

- 1.3.1 Хууль дээдлэх;
- 1.3.2 Академик эрх чөлөөг эрхэмлэх
- 1.3.3 Судалгаанд үндэслэгдсэн байх
- 1.3.4 Судлаачдын оролцоог хангах
- 1.3.5 Ил тод нээлттэй
- 1.3.6 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
- 1.3.7 Судалгааны ёс зүйг дээдлэх.



ХОЁР. Хүрээлэн, төв байгуулах, түүний бүтэц

2.1 Хүрээлэн, төвийг байгуулах

- 2.1.1 Үүсгэн байгуулагч нь хүрээлэн, төв байгуулах төслийн саналыг (Хавсралт 1)-ийн дагуу боловсруулж МУИС-ийн судалгаа хариуцсан нэгжид хүсэлт гаргана.
- 2.1.2 МУИС-ийн судалгаа хариуцсан нэгж нь баримт материалын бүрдүүлэлтэд үндэслэн шинээр байгуулагдах хүрээлэн, төвийг МУИС-ийн Ректоратын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрт үндэслэн хүрээлэн болон төвийг МУИС-ийн ректорын тушаалаар байгуулна.
- 2.1.3 МУИС-д хүрээлэн байгуулах хүсэлт гаргагч нь бүрэлдэхүүн сургууль, төв байгуулах хүсэлт гаргагч нь тэнхим байна.
- 2.1.4 Хүрээлэн, төв байгуулахад дараах үндсэн шаардлагыг баримтална. Үүнд:
 - 2.1.4.1 Шинээр байгуулагдах хүрээлэн, төвийн үйл ажиллагаа нь МУИС-ийн бусад нэгжийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй давхцахгүй байгаа тухай МУИС-ийн судалгаа хариуцсан нэгжээс Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн системийг үндэслэн тодорхойлолт гаргуулсан байх;
 - 2.1.4.2 Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал;
 - 2.1.4.3 Санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийн тооцоо;
 - 2.1.4.4 Үйл ажиллагааг батлах бүтээл, туурвил, оюуны өмч;
 - 2.1.4.5 Судалгааны шууд бус зардлын шимтгэл төлөх төлөвлөгөө.
 - 2.1.4.6 “Татан буугдсан судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааг шууд сэргээхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд энэхүү журмын 2.1-д заасан шинээр хүрээлэн, төв байгуулах нийтлэг шаардлага, журмын дагуу асуудлыг шинээр хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.2 Хүрээлэн, төвийн бүтэц, зохион байгуулалт

- 2.2.1 Хүрээлэн, төв нь МУИС-ийн нэгж байна.
- 2.2.2 Хүрээлэн, төв нь захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга (ЭНБД)-тай байна.


- 2.2.3 Хүрээлэн, төвийн захирал, ЭНБД-ын ажлыг МУИС-ийн үндсэн орон тооны докторын зэрэгтэй профессор багш, эрдэм шинжилгээний ажилтан гүйцэтгэнэ.
- 2.2.4 МУИС-ийн үндсэн орон тооны докторын зэрэгтэй профессор багш хүрээлэн, төвийн захирал, ЭНБД-аар ажилласан тохиолдолд тухайн хүрээлэн, төвөөс 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалинтай хавсран гүйцэтгэж болно.
- 2.2.5 МУИС-ийн хүрээлэн, төвийн захирлыг МУИС-ийн захирлын тушаалаар гурван жилийн хугацаатай томилно. Үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийг харгалзан дахин нэг удаа 3 жилийн хугацаатайгаар улируулан ажиллуулж болно.
- 2.2.6 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төвийн захирлыг МУИС-ийн үндсэн профессор багш нар болон гадаадад суугаа Монгол улсын иргэн эрдэмтэн, судлаач нарын дотроос судлан шалгаруулсны үндсэн дээр МУИС-ийн ректор томилно.
- 2.2.7 Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан проректор судалгааны хүрээлэн, төвийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
- 2.2.8 Хүрээлэнгийн захирал Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан проректортой үр дүнгийн гэрээ байгуулна. Төвийн захирал харьяалагдах бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиралтай үр дүнгийн гэрээ байгуулна.
- 2.2.9 Хүрээлэн, төвийн ЭНБД-ыг тус нэгжийн эрдэм шинжилгээний ажилтны гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлын нууц санал хураалтын дүнг үндэслэн МУИС-ийн Захирлын тушаалаар томилно.
- 2.2.10 Хүрээлэн, төвийн үндсэн орон тооны ажилтан нь судалгааны төсөл, мэдүүлэх, , шагнал урамшуулалд хамрагдах, мэргэжил дээшлүүлэх, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдах эрхтэй.

2.3 Хүрээлэн, төвийн дотоод журам

- 2.3.1 Хүрээлэн, төв нь МУИС-ийн дүрэм болон энэхүү нийтлэг журамд нийцүүлэн баталсан өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод журамтай байна.
- 2.3.2 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, “МУИС-ийн дүрэм”, “МУИС-ийн 2025-2030 хөгжлийн стратеги төлөвлөгөө”, “МУИС-д эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам” (2022.07.01 Захирлын тушаал №А/276), МУИС-д судалгааны үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох бусад журмуудтай нийцүүлэн баталсан хүрээлэн, төвийн дүрэм, дотоод журам нь түүний үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг бөгөөд дор дурдсан мэдээлэл багтсан байна.
- 2.3.2.1 Оноосон нэр, оршин байгаа газрын хаяг
- 2.3.2.2 Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл
- 2.3.2.3 Хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт
- 2.3.2.4 Тодорхой хугацаагаар байгуулж байгаа бол тус хугацааг тусгах
- 2.3.2.5 Хөрөнгө, үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр

2.3.2.6 Холбогдох шийдвэр, үйл ажиллагааны талаарх тайлан бусад мэдээллийг МУИС-ийн удирдлага болон холбогдох этгээдэд хүргэх, мэдээлэх үйл явц.

ГУРАВ. Хүрээлэн, төвийн үйл ажиллагаа, эрх үүрэг



3.1 Хүрээлэн төвийн үйл ажиллагаа

- 3.1.1 Хүрээлэн, төв нь суурь болон хэрэглээний шинжлэх ухааны судалгаа хийх, дотоод гадаадын байгууллагатай хамтран эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, тухайн салбарын мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, чадавхжуулах зэргийн бус сургалт зохион байгуулах, шинэ техник, технологи боловсруулж үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх, өөрийн бий болгосон оюуны өмчийг бизнесийн эргэлтэд оруулах замаар инновац, технологи дамжуулалтыг хөгжүүлэх зэрэг чиглэлээр бие даасан үйл ажиллагаа явуулна.
- 3.1.2 Хүрээлэн, төв нь үйл ажиллагаандаа академик эрх чөлөө, бүтээлч байдлыг удирдлага болгон шинжлэх ухааны үнэнийг эрэлхийлэн, багаар хамтран ажиллахыг чухалчлах ба эрдэм мэдлэгийн үнэ цэнийг эрхэмлэн, шинжлэх ухааны болон судлаачийн ёс зүйг чанд дагаж мөрдөнө.
- 3.1.3 Хүрээлэн, төв нь өөрийн оноосон нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудастай байж болох бөгөөд уг хэвлэмэл хуудсанд МУИС эсвэл харьяа бүрэлдэхүүн сургууль, нэгжийн харьяаллыг тодорхой тусгасан байна. (жишээ нь: "Монгол Улсын Их Сургуулийн харьяахүрээлэн", "..... сургуулийн харьяа төв").
- 3.1.4 Хүрээлэн, төв нь тусдаа тамга хэрэглэхгүй. Гаднын байгууллагатай гэрээ байгуулах, худалдан авах ажиллагаа, тендерт оролцох болон бусад албан ёсны үйл ажиллагаанд төв нь харьяа бүрэлдэхүүн сургуулийн, хүрээлэн нь МУИС-ийн тамгыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хэрэглэнэ.
- 3.1.5 Хүрээлэн, төвийн албан хэрэг хөтлөлт, хурлын тэмдэглэл, шийдвэрийг МУИС-ийн "Албан хэрэг хөтлөлтийн журам"-д нийцүүлэн хөтлөх бөгөөд үйл ажиллагааны баримт бичгийг жил бүр архивд шилжүүлж, хадгалалтын аюулгүй байдлыг хангана.

3.2 Судалгааны хүрээлэн, төвийн захирлын эрх, үүрэг

- 3.2.1 Хүрээлэн, төвийн захирал үндсэн, гэрээт ажилтныг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ажилтныг МУИС-ийн захирал баталгаажуулна.
- 3.2.2 Жил бүрийн 1-р сард үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж харьяалагдах нэгжийн удирдлагатай үр дүнгийн гэрээг байгуулах бөгөөд тухай жилийн 12-р сард үр дүнгийн гэрээний тайланг хэлэлцүүлэн дүгнүүлнэ. Гэрээний үр дүнгийн биелэлтийг хавсралт-2-ын дагуу дүгнүүлж Судалгаа эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид дараа оны 1 дүгээр сард багтаан хүргүүлнэ.

- 3.2.3 Гадаад, дотоод хамтын ажиллагааны гэрээ байгуулсан тохиолдолд МУИС-ийн хамтын ажиллагаа хариуцсан нэгжид бүртгүүлж гэрээний биелэлтийг жил бүр тайлагнана.
- 3.2.4 Хүрээлэн, төвийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шаардлагатай тохиолдолд бусад бүрэлдэхүүн сургуулийн багш, докторант, магистрант, эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдыг оролцох боломжоор хангаж ажиллана.
- 3.2.5 Хүрээлэн, төвийн захирал тухайн жилийн судалгааны үйл ажиллагааны тайланг МУИС-ийн Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем (ЭШММС)-д бүртгүүлнэ.



ДӨРӨВ. Хүрээлэн, төвийн санхүүжилт, үнэлгээ

4.1 Хүрээлэн, төвийн санхүүжилт

- 4.1.1 Хүрээлэн, төвийн өмч хөрөнгө нь МУИС-ийн өмчлөлд байна.
- 4.1.2 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төв нь тусдаа бие даасан данстай байна. МУИС-ийн хүрээлэн, төвийн санхүүгийн үйл ажиллагаа нь зөвхөн МУИС-ийн эрдэм шинжилгээний эсвэл тухайн харьяа бүрэлдэхүүн сургуулийн дансаар дамжин явагдах бөгөөд тусдаа данстай байхыг хориглоно.
- 4.1.3 Хүрээлэн, төвийн хөрөнгө, үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
- 4.1.3.1 Монгол Улсын Засгийн газрын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, суурь зардал;
 - 4.1.3.2 МУИС-ийн төсвийн санхүүжилт (байгууллагын бодлогоор дэмжих чиглэлийн хүрээлэн, төвийн хувьд);
 - 4.1.3.3 Олон улсын болон үндэсний хэмжээний судалгааны ажлын санхүүжилт;
 - 4.1.3.4 Хүрээлэн, төвийн үйл ажиллагаанаас олох орлого;
 - 4.1.3.5 Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл, захиалгат болон гэрээт ажил;
 - 4.1.3.6 Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн шууд бус зардлын шимтгэл;
 - 4.1.3.7 Хандив, тусламж.

4.2 Хүрээлэн, төвийн үйл ажиллагааны үнэлгээ

- 4.2.1 Эрдэм шинжилгээ, судалгаа эрхэлсэн проректор хүрээлэнгийн үйл ажиллагааг үр дүнгийн гэрээний гүйцэтгэлээр санхүүгийн жил тутамд энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан иж бүрэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн харьяа судалгааны төвийн гүйцэтгэлийн үнэлгээг харьяа сургуулийн удирдлага үнэлж үр дүнг МУИС-ийн судалгаа хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 4.2.2 Эрдэм шинжилгээ, судалгаа эрхэлсэн проректор шаардлагатай тохиолдолд хүрээлэн, төвийн үйл ажиллагааны үнэлгээг гүйцэтгэх мэргэжлийн шинжээчийн багийг таваас доошгүй профессор,

судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр томилж, удирдамжаар ханган дүгнэлт гаргуулна.

- 4.2.3 МУИС-ийн хүрээлэн, төвийн үнэлгээ нь тэдгээрийг урамшуулах, дэмжлэг үзүүлэх, өөрчлөн байгуулах эсхүл татан буулгах, эрдэм шинжилгээ, судалгаа эрхэлсэн проректортой байгуулсан үр дүнгийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл болно.



ТАВ. Хүрээлэн, төвийг татан буулгах

5.1 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төвийн ажлын үнэлгээ нь хангалтгүй тохиолдолд бүтцийг өөрчлөх, татан буулгах саналыг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

5.2 МУИС-ийн хүрээлэн, төвийг МУИС-ийн захирлын тушаалаар дараах тохиолдолд татан буулгана.

- 5.2.1 Төлөвлөгөөт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж дууссан;
- 5.2.2 Зорилгод нийцсэн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон;
- 5.2.3 Үр дүнгийн гэрээнд заасан гүйцэтгэл хангалттай бус эсхүл үйл ажиллагаа явуулаагүй;
- 5.2.4 Санхүүжилтийн эх үүсвэргүй;
- 5.2.5 Үйл ажиллагааг зогсоох талаар шүүхийн шийдвэр гарсан;
- 5.2.6 Хамт олны гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас олонхын саналаар татан буулгах тухай шийдвэр гаргасан;
- 5.2.7 Үндсэн зорилгын чиглэлийн дагуу биш үйл ажиллагаа явуулсан (улс төрийн гэх зэрэг);
- 5.2.8 Нэг жилийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй байх;
- 5.2.9 Хоёр жил дараалан гүйцэтгэлийн үнэлгээний оноо 60-аас бага байх;
- 5.2.10 Бүтэн цагаар ажиллуулсан хүний тоонд шилжүүлсэн утга (БЦАХТШУ) бүхий хүний нөөц орон тооны доод хязгаарт хүрэхгүй болсон;

5.3 Судалгааны хүрээлэн, төв татан буугдахад мөнгөн хөрөнгө, тоног төхөөрөмж нь бүрэлдэхүүн сургуулийн эзэмшилд шилжинэ.

5.4 Судалгааны хүрээлэн, төв татан буугдахад хүний нөөцийн асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


ЗУРГАА. Маргаан шийдвэрлэх

6.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Журмын хавсралт 1

Хүрээлэн, төв байгуулах төслийн саналын агуулга

1. Хүрээлэн, төвийн нэр
2. Хүрээлэн, төвийн захиралд нэр дэвшигчийн намтар, ажлын туршлага, судалгааны өгүүлэл, бүтээлийн жагсаалт
3. Хүний нөөц, гишүүдийн намтар, бүтээлийн жагсаалт
4. Хүрээлэн, төвийг байгуулах үндэслэл
5. Үйл ажиллагааны зорилго, зорилтууд
6. Зохион байгуулалт
7. Оршин байх хаяг
8. Судалгааны дэд бүтэц
9. Үйл ажиллагааны төлөвлөгөө
10. Төсөв
11. Хүрээлэн, төвийн хүлээгдэх судалгааны үр дүн
12. Харьяалагдах бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр
13. Хүрээлэн, төвийн үйл ажиллагаа нь МУИС-ийн бусад нэгжийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй давхцахгүй байгаа тухай МУИС-ийн судалгаа хариуцсан нэгжээс Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн системийг үндэслэн тодорхойлолт гаргуулсан байх




Журмын хавсралт 2

Хүрээлэн, төвийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан тухайн жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээр үнэлнэ. Тухайн тэргүүлэх чиглэлд заагдсан ажлын төрлөөс хүрээлэн 3-аас цөөнгүй, төв 2-оос цөөнгүй ажлыг гүйцэтгэхээр төлөвлөнө.

Үзүүлэлт	Агуулга	 онд төлөвлөсөн
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ	Үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан тухайн жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээр үнэлнэ. Тухайн тэргүүлэх чиглэлд заагдсан ажлын төрлөөс хүрээлэн 3-аас цөөнгүй, төв 2-оос цөөнгүй ажлыг гүйцэтгэхээр төлөвлөнө. Үүнд: - WoS/Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх - WoS/Scopus-д бүртгэлтэй бүтээлтэй хэвлэлийн газарт бүтээл хэвлүүлэх /proceedings, book, chapter.../ - ОУ-д индекстэй сэтгүүл хөгжүүлэлт - Тухайн жилийн судалгааны төслийн орлого /50 сая-аас дээш байх/ - Пост доктор ажиллуулах - Патент авсан байх - Инновацын бүтээгдэхүүн хөгжүүлсэн байх	70
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. СУРГАЛТ	Үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан тухайн жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээр үнэлнэ. Тухайн тэргүүлэх чиглэлд заагдсан ажлын төрлөөс 2-оос багагүй ажлыг гүйцэтгэхээр төлөвлөнө. Үүнд: - Зэргийн бус сургалт зохион байгуулах - Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх - Судалгааны туслах ажилтан ажиллуулах /ахисан түвшний оюутан/ - Сургалттай холбоотой бусад үйл ажиллагаанаас орлого олох	10

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. НИЙГМИЙН ОРОЛЦОО	Үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан тухайн жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээр үнэлнэ.Тухайн тэргүүлэх чиглэлд заагдсан ажлын төрлөөс 2-оос багагүй ажлыг гүйцэтгэхээр төлөвлөнө. Үүнд: - Олон нийтэд судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах - SDG зорилтын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулах - Улсын хэмжээний хөгжлийн бодлогын бичиг барим боловсруулах - Их сургуулийн хөгжлийн бодлогын бичиг баримт боловсруулах	
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. ХҮНИЙ НӨӨЦ	Үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан тухайн жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээр үнэлнэ.Тухайн тэргүүлэх чиглэлд заагдсан ажлын төрлөөс 2-оос багагүй ажлыг гүйцэтгэхээр төлөвлөнө. Үүнд: - Үндсэн орон тооны судлаачийн тоо (бүтэн цагаар ажиллуулсан хүний тоонд шилжүүлсэн утга: хүрээлэн 8, төв 3 –с доошгүй байх нөхцөлийг хангасан байх) - Зочин судлаачийн тоо (гадаад болон дотоод) - Давхар харьяаллаар гадаадын их сургууль, судалгааны байгууллагын судлаачийг ажиллуулах	10
Нийт оноо		100